

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/17/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Улаанбаатар хот

2024 он

Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,

тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг

Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: С.Нацагдорж

Утас: 260512 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Эрдэнэзул

Утас: 261740 Цахим хаяг: erdenezulb@audit.gov.mn

Аудитор: Д.Эрдэнэчимэг

Утас: 261740 Цахим хаяг: Erdenechimegda@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА
Ч.МӨНХТУЯА ТАНАА

2024.03.25 № 07/847
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Иргэний нисэхийн ерөнхий газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Иргэний нисэхийн ерөнхий газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь аудитын дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 5,182.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс давж, дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Тухайлбал:

- Төлбөрийн чадваргүй болсон Чингис хаан банканд байршуулсан 2,661.9 сая төгрөгийн үлдэгдлийг барагдуулаагүй;
- Тайлант онд 150,000.0 сая төгрөгийг навигацийн орлогоос төвлөрүүлэхээс 5,000.0 сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлт 3.3 хувьтай;
- Гадаадын агаарын тээвэрлэгч нэр бүхий 10 компанийн 2001 оноос 2004 онуудад үүссэн 1,987.3 сая төгрөгийн олон жилийн насжилттай авлагыг барагдуулаагүй, найдваргүй болох эрсдэл үүссэн;
- Харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт сул байгаагаас нийт 2,452.8 сая төгрөгийн материаллаг зөрчил илэрсэн зэрэг нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.5, 16 дугаар зүйлийн 16.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 18

дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6 дахь заалтуудтай нийцэхгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Засгийн газрын 2023 оны “Орон нутгийн чиглэлд хуваарьт нислэг үйлдэх зарим арга хэмжээний тухай” 201 дүгээр тогтоолоор Иргэний нисэхийн үндэсний төвийн 2023 оны төсөвт зохицуулалт хийж, Монголын иргэний агаарын тээвэр ТӨХК-д орон нутгийн нислэгийн үйл ажиллагааг эхлүүлэх, нислэгт дунд оврын агаарын хөлөг шинээр ашиглахад шаардагдах хөрөнгийг шийдвэрлэхээр тус компаниас авах 2,698.1 сая төгрөгийн авлагыг суутган тооцож, 5,901.9 сая төгрөгийн татаас санхүүжилт олгосон байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2023 оны А/277 дугаар тушаал, Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын зөвлөлийн 2023 оны 14/03 дугаар шийдвэр, тухайн орнуудын шүүхийн шийдвэрийг тус тус үндэслэн гадаадын агаарын тээвэрлэгч Украин улсын AERSIT, ОХУ-ын Трансарэро, ОХУ-ын Бүгд найрамдах Татарстан улсын ВИМ зэрэг компаниудтай холбогдох нийт 1,135,379.11 ам.долларын авлагыг данснаас хасаж бүртгэсэн байна.

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэлд төлбөрийн чадваргүй болсон Чингис хаан банканд байршуулсан 2,661.9 сая төгрөгийн үлдэгдэл байна.

Бусад асуудлын хэсэг

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2023 онд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний 119 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 112 арга хэмжээний гүйцэтгэл 89.0 хувьтай, 7 арга хэмжээг он дамжуулан хэрэгжүүлж байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн нэгтгэсэн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	136,575,937.6	151,554,575.7
Мөнгөн хөрөнгө	42,616,874.2	53,542,635.0
Авлага	48,220,936.8	51,841,554.4
Урьдчилж төлсөн зардал	472,554.6	477,605.1
Бараа материал	20,424,880.6	20,851,589.7
Бусад эргэлтийн хөрөнгө	24,840,691.4	24,841,191.4
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,855,027,971.5	1,776,779,957.2
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,855,027,971.5	1,776,779,957.2
Биет хөрөнгө	1,338,429,089.7	1,259,443,213.6
Биет бус хөрөнгө	477,176,392.2	480,767,927.9
Хойшлогдсон татварын хөрөнгө	5,055,043.1	2,003,787.5
Дуусаагүй барилга	34,367,446.5	34,565,028.2
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,991,603,909.1	1,928,334,532.8
НИЙТ ӨР ТӨЛБӨР	32,626,724.0	29,601,554.5
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	7,324,596.8	5,322,641.0
Өглөг	7,301,784.7	5,315,094.0
Урьдчилж орсон орлого	22,812.1	7,547.0
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	25,302,127.2	24,278,914.5
Хойшлогдсон татварын өглөг	3,066,802.8	2,984,577.2
Урьдчилж орсон орлого /ХО/	22,235,324.4	21,294,336.3
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,958,977,185.1	1,898,732,978.4
Засгийн газрын хувь оролцоо	1,958,977,185.1	1,898,732,978.4
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	1,979,696,925.8	1,993,506,509.0
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	54,679,072.9	42,425,126.4
Хуримтлагдсан үр дүн	(75,398,813.6)	(137,198,657.0)
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,991,603,909.1	1,928,334,532.8

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	130,811,121.4	162,959,311.4
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	127,853,711.3	159,991,835.2
Нийтлэг татварын бус орлого	127,853,711.3	159,991,835.2
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,957,410.1	2,967,476.2
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	205,743,978.4	225,176,923.1
УРСГАЛ ЗАРДАЛ	205,743,978.4	225,176,923.1
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	189,743,978.4	211,576,923.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	68,539,243.2	74,286,889.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,769,469.8	9,546,400.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,249,514.3	3,325,606.6
Хангамж, бараа материалын зардал	4,750,391.5	5,499,610.7
Эд хогшил, урсгал засварын зардал	3,200,395.0	3,259,352.5
Томилолт, зочны зардал	775,592.1	1,590,897.0
Бараа үйлчилгээний бусад зардал	97,459,372.5	114,068,166.4
ТАТААС	-	8,600,000.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,000,000.0	5,000,000.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	(74,932,857.0)	(62,217,611.7)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	22,343,221.5	2,955,230.5
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	18,787,761.5	9,900,003.0
ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ДҮН	-	656,699.9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	(71,377,397.0)	(69,819,084.1)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	149,810,675.9	155,527,953.0
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	146,853,265.8	152,560,476.8
Нийтлэг татварын бус орлого	146,853,265.8	152,560,476.8
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,957,410.1	2,967,476.2
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	131,165,854.2	141,056,741.2
УРСГАЛ ЗАРДАЛ	131,165,854.2	141,056,741.2
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	108,834,431.0	123,641,726.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	64,743,656.9	73,760,856.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,702,535.9	13,164,585.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,683,247.2	4,522,522.9
Хангамж, бараа материалын зардал	4,333,081.0	4,988,866.0
Нормативт зардал	281,176.8	350,149.0
Эд хогшил, урсгал засварын зардал	3,950,885.5	3,414,682.3
Томилолт, зочны зардал	760,504.6	1,614,467.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,276,751.8	19,879,839.9
Бараа үйлчилгээний бусад зардал	102,591.3	1,945,757.1
ХҮҮ	-	42,804.5
ТАТААС	-	5,901,923.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,331,423.2	11,470,286.5
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	18,644,821.7	14,471,211.8
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	-	438,118.2
Хүлээн авсан хүүний орлого	-	438,118.2
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	7,992,690.7	3,984,569.3
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,992,690.7	3,984,569.3
Дотоод эх үүсвэрээр	7,992,690.7	3,984,569.3
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(7,992,690.7)	(3,545,451.0)
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	10,652,131.0	10,925,760.8
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	31,964,743.2	42,616,874.2
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	42,616,874.2	53,542,635.0

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,000,373,861.8		2,000,373,861.8
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,000,373,861.8		2,000,373,861.8
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	22,820,321.3		22,820,321.3
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			
Эздийн өмчийн бусад хэсэг	7,160,398.9		7,160,398.9
Тайлант үеийн үр дүн	(71,377,397.0)		(71,377,397.0)
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,958,977,185.1		1,958,977,185.1
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-		-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,958,977,185.1		1,958,977,185.1
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	9,574,877.4		9,574,877.4
Эздийн өмчийн бусад хэсэг			
Тайлант үеийн үр дүн	(69,819,084.1)		(69,819,084.1)
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,898,732,978.4		1,898,732,978.4

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл				
I. НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,967,476,200.00	2,967,476,200.00	-	100.0
III. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	2,967,476,200.00	2,967,476,200.00	-	100.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,803,832,300.00	2,803,832,300.00	-	100.0
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	2,395,557,700.00	2,395,557,700.00	-	100.0
Үндсэн цалин	1,976,400,000.00	1,976,400,000.00	-	100.0
Нэмэгдэл, урамшил	284,394,000.00	284,394,000.00	-	100.0
Унаа, хоолны хөнгөлөлт	134,763,700.00	134,763,700.00	-	100.0
Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл	299,444,800.00	299,444,800.00	-	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	66,477,900.00	66,477,900.00	-	100.0
Гэрэл цахилгаан	24,282,000.00	24,282,000.00	-	100.0
Түлш, халаалт	28,708,200.00	28,708,200.00	-	100.0
Цэвэр, бохир ус	13,487,700.00	13,487,700.00	-	100.0
Хангамж, бараа материалын зардал	8,029,100.00	8,029,100.00	-	100.0
Бичиг хэрэг	2,024,700.00	2,024,700.00	-	100.0
Тээвэр шатахуун	2,017,900.00	2,017,900.00	-	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,426,300.00	1,426,300.00	-	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх зүйлс	2,560,200.00	2,560,200.00	-	100.0
Нормативт зардал	3,002,400.00	3,002,400.00	-	100.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,002,400.00	3,002,400.00	-	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	2,548,100.00	2,548,100.00	-	100.0
Багаж, техник хэрэгсэл	1,408,300.00	1,408,300.00	-	100.0
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,139,800.00	1,139,800.00	-	100.0
Томилолт, зочны зардал	128,500.00	128,500.00	-	100.0
Дотоод албан томилолт	128,500.00	128,500.00	-	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,876,000.00	12,876,000.00	-	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	-	-	-
Даатгалын үйлчилгээ	3,947,200.00	3,947,200.00	-	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	94,800.00	94,800.00	-	100.0
Тээврийн хэрэгслийн оношилгоо	37,900.00	37,900.00	-	100.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээний зардал	8,350,200.00	8,350,200.00	-	100.0
Газрын төлбөр	445,900.00	445,900.00	-	100.0
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	-	-	-
Бараа үйлчилгээний бусад зардал	15,767,800.00	15,767,800.00	-	100.0
Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	15,767,800.00	15,767,800.00	-	100.0
ТАТААС, УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	163,643,900.00	163,643,900.00	-	100.0
Засгийн газрын урсгал шилжүүлэг	143,975,900.00	143,975,900.00	-	100.0
Олон улсын байгууллагын гишүүний татвар	143,975,900.00	143,975,900.00	-	100.0
Бусад урсгал шилжүүлэг	19,668,000.00	19,668,000.00	-	100.0
Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	2,269,500.00	2,269,500.00	-	100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,398,500.00	17,398,500.00	-	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,967,476,200.00	2,967,476,200.00	-	100.0
Төсвөөс санхүүжих	2,967,476,200.00	2,967,476,200.00	-	100.0
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
Төсвийн байгууллага	1	1	-	100.0
АЖИЛЛАГСАД БҮГД	106	106	-	100.0
Удирдах ажилтан	2	2	-	100.0
Үйлчлэх ажилтан	8	8	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	96	96	-	100.0

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар орон нутгийн болон харьяа байгууллагуудын санхүүгийн тайлагналтай холбоотой нийт 552.1 сая төгрөгийн 6 алдаа¹ илэрснээс 536.9 сая төгрөгийн 3 алдааг аудитын явцад залруулж, 15.2 сая төгрөгийн алдааг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн.

Аудитаар нийт 5,182.5 сая төгрөгийн 28 зөрчил² илэрснээс, 157.3 сая төгрөгийн зөрчилд 5 төлбөрийн акт тогтоож, 2,290.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах 8 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2,735.1 сая төгрөгийн 15 зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн 5,182.5 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшин 2,245.3 сая төгрөгөөс давсан байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө

Төвлөрүүлэн захирагч

Төлбөрийн акт

Барьцаа хөрөнгийн дансанд 2017-оос 2019 онд байршуулж, 5-7 жил болсон 25 хуулийн этгээдтэй холбоотой 49.6 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, тухайн харилцагч нарт өгөх эсэх нь тодорхойгүй байхад улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 “энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ”, 45 дугаар зүйлийн 45.2 “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ: 45.2.2 төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл” гэж тус тус заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Барьцаа хөрөнгийн үлдэгдлийг улсын төсөвт нөхөн төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны А/100 дугаар тушаалаар баталсан журмыг үндэслэн тус байгууллагын даргын тушаал шийдвэргүй, төлөвлөгөөнд тусгаж батлуулалгүйгээр 9 оюутны сургалтын төлбөрт 18.0 сая төгрөг олгож, анхан шатны баримтгүй зардалд бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.2 “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, төлөвлөгдөөгүй зардлыг санхүүжүүлэхгүй байх албан шаардлага өгсөн.

Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа байгууллагуудад нийт 2,452.8 сая төгрөгийн материаллаг зөрчил илэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.37 “төсвийн төвлөрүүлэн захирагч гэж төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг”, 14 дүгээр зүйлийн 14.2.3 “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 14.2.5 “өөрийн эрхлэх

асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах”, 16 дугаар зүйлийн 16.5.6 “дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 “Агентлагийн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга нэгжийнхээ өдөр тутмын үйл ажиллагааг удирдаж, үр дүнг агентлагийн даргын өмнө хариуцна” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн төвлөрүүлэн захирагчаас гаргасан шийдвэрийг үндэслэн алба, нэгжүүдийн хөрөнгийн хөдөлгөөнийг хийх, дотоод хяналтыг сайжруулах, дээрх зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага өгсөн.

Зөвлөмж

1. Гадаадын агаарын тээвэрлэгч компаниудтай холбоотой үүссэн авлагын асуудал

Илрүүлэлт: Гадаадын агаарын тээвэрлэгч нэр бүхий 10 компанийн 2001 оноос 2004 онуудад үүссэн 1,987.3 сая төгрөгийн олон жилийн насжилттай авлагыг барагдуулаагүй, найдваргүй болох эрсдэл үүссэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Олон жилийн насжилттай авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулах, цаашид агаарын тээврийн гэрээт бус компаниудад нэг удаагийн нислэгийн үйлчилгээ үзүүлэхдээ тухайн харилцагчаас төлбөрийн урьдчилгаа байршуулж байх асуудлыг шийдвэрлэн, мөрдөж ажиллах.

2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй асуудал

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэлд төлбөрийн чадваргүй болсон Чингис хаан банканд байршуулсан 2,661.9 сая төгрөгийн үлдэгдэл байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 14.2.5 “өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах”, 15 дугаар зүйлийн 15.4.1 “төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх”, 16 дугаар зүйлийн 16.5.6 “дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэж тус тус заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Харилцагч банкнаас мөнгөн хөрөнгийг татан авах асуудлыг шуурхай шийдвэрлүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах

3. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 207 төрлийн 300.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байгааг ашиглах болон дахин үнэлүүлэн, бодит үнэ цэнээр бүртгэх асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 “Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох”, Засгийн газрын 2006 оны 388 дугаар тушаалын нягтлан бодох бүртгэлийн зааврын дагуу дансны үнэ бодит үнээсээ материаллаг зөрүүтэй байгаа биет болон биет бус хөрөнгийг дахин үнэлэх, цаашид ашиглах боломжгүй бол данснаас хасах асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлэх”, ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах,

бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалттай нийцээгүй байна

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа, өртгийг бодитой тогтоож бүртгэлд тусгах талаар зохих байгууллагад хандан шийдвэрлүүлэх

4. Навигацийн орлого бүрдүүлэлтэй холбоотой асуудал

Тайлант онд улсын төсөвт төвлөрүүлэх навигацийн орлогоос 5,000.0 сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлт 3.3 хувьтай байна.

Энэ нь Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйл "Монгол Улсын төсөвт 2023 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа болон бусад байгууллага доор дурдсан орлого төвлөрүүлнэ" 15-д "...Зам, тээврийн хөгжлийн сайд Иргэний нисэхийн ерөнхий газар 150,000.0 сая..." төгрөг, гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн орлогыг бодитой төлөвлөн, Улсын төсөвт төвлөрүүлэх навигацийн орлогыг бүрэн төвлөрүүлэх.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудал

Аудитаар нийт 552.1 сая төгрөгийн алдаа³ илэрснээс аудитын явцад 536.9 сая төгрөгийн алдааг залруулж, 15.2 сая төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Шалгагдагч байгууллагын нэр	Нийт алдаа		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
					Тоо	Дүн	Тоо	Дүн		
Иргэний нисэхийн үндэсний төв	1	532,816.0			1	532,816.0				
ИНҮТ-Орон нутаг дахь харьяа байгууллагууд	5	19,313.6			2	4,129.3	-		3	15,184.3
НИЙТ	6	552,129.6			3	536,945.3			3	15,184.3

Аудитаар нийт 5,182.5 сая төгрөгийн зөрчил⁴ илэрснээс, 157.3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 2,292.0 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 2,735.1 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Шалгагдагч байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс:					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Иргэний нисэхийн ерөнхий газар	7	2,729,611.4	1	49,658.4	2	18,000.0	4	2,661,953.0
ИНҮТ-Улаанбаатар хот дахь харьяа байгууллагууд	15	2,429,186.8	3	107,307.3	6	2,272,060.3	6	49,819.2
ИНҮТ-Орон нутаг дахь харьяа байгууллагууд	6	23,692.0	1	366.8	0	-	5	23,325.2
НИЙТ	28	5,182,490.2	5	157,332.5	8	2,290,060.3	15	2,735,097.4

³ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

⁴ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 2,102.2 сая төгрөгийн зөрчил илэрснээс 2,102.2 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Шалгагдагч байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Иргэний нисэхийн ерөнхий газар	3				-		3	-
ИНУТ-Улаанбаатар хот дахь харьяа байгууллагууд	6	2,102,196.2			1	-	5	2,102,196.2
НИЙТ	9	2,102,196.2	-	-	1	-	8	2,102,196.2